

**“МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ ЁС ЗҮЙН ДҮРМИЙГ ШИНЭЧЛЭН  
БАТЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙГ ЭЦСИЙН  
ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭСЭН ТАЛААРХ ЁС ЗҮЙ, САХИЛГА  
ХАРИУЦЛАГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТАНИЛЦУУЛГА**

2021 оны 12 дугаар  
сарын 30-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, С.Ганбаатар, Н.Ганибал, Л.Энх-Амгалан нараас 2021 оны 03 дугаар сарын 24-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаараа “Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явууллаа.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасны дагуу төслийн 4.5, 4.6 дахь хэсгийг гүйцээн боловсруулах, мөн төслийн 7.4 дэх хэсэгт найруулгын шинжтэй засвар хийх чиглэл өгсний дагуу зарчмын зөрүүтэй санал гаргаж санал хураахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл, Байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.БАТ-ЭРДЭНЭ

